

**“Erasmus” төслийн Эко Ази дээд сургуулийн багийн
ээлжит онлайн хурлын тэмдэглэл**

2021 оны 06 дугаар
сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

**ТХГН-ИЙН экосистемийн үйлчилгээний менежментийн чиглэлээр магистрын
сургалтын хөтөлбөр боловсруулах төслийн Ажлын багц /АБ1/ -ийн хүрээнд
хийсэн санал асуулгын үр дүнгийн боловсруулалт болон сургалтын
хөтөлбөрийн талаар**

Хурал хийсэн газар: Хурлыг google meet ашиглан <https://meet.google.com/ufs-ubsu-gbi> линкээр хийлээ. Хурлыг 09:05 цагт эхэлж, 10:45 цагт дуусгав.

Хэлэлцэх асуудал:

1. АБ1-ийн хүрээнд хийгдсэн судалгааны үр дүнгээ SPSS дээр боловсруулсанаа Д.Нарантогтох танилцуулна
2. Магистрын сургалтын хөтөлбөрийн талаар А.Эрдэнэбаяр танилцуулна.
3. Вэб сайт шинэчлэлтийн ажлын явцыг А.Эрдэнэбаяр танилцуулна.

Хуралд оролцсон:

ЭКО АЗИ БОМДС-ийн Ерөнхий захирал Ц.Адъяасүрэн, ерөнхий менежер А.Эрдэнэбаяр, эрдмийн зөвлөлийн гишүүн Д.Энэбиш, ахлах багш Э.Доржпагма, Аргун манлайлал ТББ-ын менежер Д.Нарантогтох нар оролцов.

Хэлэлцсэн нь:

1. Д.Нарантогтох: Судалгааны нийт асуултын 2-8-р асуулт хүртэл боловсруулсанаа хүснэгтээр танилцуулав.

Д.Нарантогтох: Асуулт бүр дотор нарийн задаргаа хийж оруулах уу? Санал асуулгад хоорондоо хамааралтай, мөн чухал гэж үзсэн асуултуудыг илүү статистик боловсруулалт хийх эсэх дээр санал авмаар байна? Энд дундаж утга, харьцуулалт, давтамжийг гаргаж өгсөн. Мөн 2-р асуултын хариулт нь 10-р асуулттай хамааралтай байж болох тул энд дараалуулан орууллаа.

Ц.Адъяасүрэн: 2р асуулт буюу Тусгай хамгаалалттай газар нутагт экосистемийн үйлчилгээний чиглэлээр мэргэшсэн (мэргэжил, албан тушаал) -ын хувьд тухайн байгууллагад тохирох мэргэжилтэн олоход бэрхшээлтэй байдаг уу? гэсэн асуултанд 2,6 хувь нь үгүй гэсэн байна. Ямар байгууллагууд ийм хариулт өгсөнийг мэдэж юутай холбоотойг тогтоох хэрэгтэй.

Э.Доржпагма: Бусад хамтрагч байгууллагууд маань бүгд судалгааны тайлангаа өгсөн байгаа учраас бид одоо энэ гаргасанаа гүйцээгээгээд өгч байх нь зүйтэй болвуу гэсэн саналтай байна.

А.Эрдэнэбаяр: Би мөн тийм саналтай байна.

2. А.Эрдэнэбаяр: Д.Нарантогтох өмнөх хуралд суугаагүй учраас дахин тайлбар хийв. Магистрын сургалтын хөтөлбөрийг урьдчилсан байдлаар 2 хэлбэрээр бэлтгэж танилцуулав. 1-р хувилбар БСШУЯ хүлээн зөвшөөрдөг хэлбэр 2-р хувилбар ЕХ-ны Erasmus+ төслөөс санал болгож буй хэлбэр болох модуль хэлбэр. Урьдчилсан хөтөлбөр боловсруулахдаа А-174 сургалтын төлөвлөгөөг ашигласан мөн ЕХ-ны Erasmus+ төслийн хүрээнд хийгдсэн судалгааны үр дүнгээс тодорхой хэмжээгээр оруулсан болно.

Д.Энэбиш болон Э.Доржпагма багш нараас сэдвийн хүрээнд олгох мэдлэг чадварын талаар бичсэн word файлыг хүлээн авсан оруулж амжаагүй байгаа.

Ц.Адъяасүрэн: Бид Улаан-Удэд болох анхдугаар хурлын 3 сэдвээр Злангаар нь бэлтгэж байна. Магистрын сургалтын хөтөлбөрийн агуулга маань энэ хуралд хэлэлцэгдэх 1 сэдэв нь болж байгаа.

А.Эрдэнэбаяр: Энэ хөтөлбөрөө төслийн хүрээнд бэлдэхэд бид модулиар бэлдэх хэрэгтэй. Харин БШУ-ны сайдын 2014 оны 03 –р сарын 13-ны өдрийн “Мэргэжлийн чиглэл индекс шинэчлэн батлах тухай” А/78 тоот тушаал2. Боловсрол шинэчлэх ухааны сайдын 2014 оны 04-р сарын 28-ны өдрийнМагистрын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага” А/174 тоот тушаа сургалтын төлөвлөгөөний дагуу хийх шаардлагатай байгаа. Үүнийг Э.Доржпагма ОУ-ын хурал дээр тодруулах хэрэгтэй байна.

3. А.Эрдэнэбаяр сургуулийн вэб хуудасны шинэчлэлт хэрхэн явагдаж байгаа талаар цэс бүрээр нь танилцуулав.

Д.Нарантогтох: Төслийн мэдээллээ 1 цэс дотроо оруулаад мэдээгээ тусад нь оруулаад дотроо 4 хэсэг байвал зүгээр гэж бодож байна. Хэтэрхий олон юм шиг санагдаж байна.

А.Эрдэнэбаяр: Мэдээлэл давхцуулахгүйн үүднээс АБ бүрээр 7 хэсэг болгож оруулсан байгаа.

Ц.Адъяасүрэн: Тийм байна тэр нь 7 хэсэг байх нь зөв юм байна.

Э.Доржпагма: Сургуулийн мэйл хаягаа вэб хуудасны домэйн нэрээр авах хэрэгтэй гэж бодож байна. Ер нь багцаар нь авбал багш нар мөн сургуулийн вэб хуудасны домэйн нэрээр мэйл хаягтай болж чадна.

Д.Нарантогтох: Хамтрагч байгууллагуудын вэб хуудсыг холбож өгөх хэрэгтэй гэж бодож байна.

Шийдвэрлэсэн нь:

1. Судалгааны тайланг Д.Нарантогтох бүх гишүүд рүү илгээж үүн дээр асуулт бүрийн дүгнэлтийг англи болон монгол хэл дээр бүгд өөр өөрийн санаагаа бичиж өгөхөөр тохиролцлоо.
2. Бүх багш нар сургалтын модуль дотор сэдэв бүрээр дэлгэрэнгүй мэдээлэл өгөхөөр болов.
Наадмын цаг хугацааг ашиглаж анхдугаар хурлын эдгээр 3 сэдвүүдээ хэлэлцэж цахим хурал семинар зохион байгуулж болох талаар ярилцав.
3. Сургуулийн вэб хуудасны домэйн нэр орсон албан мэйл хаягуудтай болохоор болов. Сургуулийн вэб хуудсыг бусад хамтрагч байгууллагуудын вэб хуудастай холбуулахаар тохиролцов.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Э.ДОРЖПАГМА

ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН :

Ц.АДЪЯАСҮРЭН